



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/260

Мөрөн сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх цагийн хязгаарыг түр
хугацаагаар хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийг 2024 онд “Хүүхэд хөгжил, хамгааллыг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдийн эрх зөрчигдөх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Энэ өдөр архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг иргэн, аж ахуйн нэгжийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж хяналт, шалгалтыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа А.Алтанцоож)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д тус тус даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ